

Ш. Бира

**ШИНЖЛЭХ УХААНЫ СОЦИАЛИЗМ ТАРИАЧДЫН  
ОЮУН САНААГ ХЭРХЭН ӨӨРЧИЛДӨГ ТУХАЙ\***

Социализмын үед нийгмийн оюун санаа, тухайлбал тариачдын оюун санааг хэрхэн өөрчлөн хувиргадаг тухай асуудал нь төдий л судлагдаагүй болно. Хөгжиж байгаа орнуудын тухай бичихдээ хүмүүс ихэвчлэн юуны өмнө эдийн засгийн асуудлыг л боддог. Энэ бол зөв боловч өрөөсгөл талтай ойлголт мөн. Хөгжиж байгаа орнуудыг судалсан одоогийн байдалд тэдгээр орны нийгмийн хөгжил дэвшлийн тухай бүх асуудлыг диалектик аргаар иж бүрэн судлах явдал онцгой чухал ач холбогдолтой болж байна. Хөгжиж байгаа орнуудын нийгмийн оюун санааны амьдралын тухай асуудлыг судлан боловсруулахад илүү их анхаарах цаг нэгэнт болжээ.

Орчин үед колони ба хараат байсан орнуудын нийгмийн оюун санааны амьдрал, ялангуяа тэдгээр орны хүн амын дийлэнх болох тариачдын оюун санааны хөгжлийн тухай асуудал бол нийгмийн хөгжлийн хамгийн чухал бөгөөд тулгамдсан асуудлуудын нэг болж байна.

Дэлхий ертөнцөд анхны социалист улс буй болсон цагаас хойш нийгэм-улс төрийн байдалд нь гарсанаас дутуугүй түүхэн их гүнзгий өөрчлөлтүүд нийгмийн оюун санаанд ч мөн нэгэн адил гарчээ. Энэ бол дэлхийн хэсэг орны соёл, үзэл суртлын мандалд ялгуусан социалист хувьсгал болсон, социалист шинэ соёл бүрэлдэн тогтсон, хөдөлмөрчин олон түм ний оюун санааны амьдрал үндсээрээ өөрчлөгдсөн үе байлаа. Одоо коммунист иргэншил дэлхийн хэмжээнд үнэхээр бодитой зүйл нэгэнт боллоо.

Орчин үед дэлхий дахинаа харилцан уялдаа бүхий хоёр үйл явц гарч байна. Үүнд: нэг талаар социалист орнуудын ард түмний оюун санааны амьдрал улам бүр ойртон нягтран интернационалчлагдаж байгаа ба, нөгөө талаар Ази, Африк, Латин Америкийн колони ба хараат байсан орнуудын ард түмний үндэсний ухамсар улам дээшилж, үндэсний соёл нь сэргэн мандаж байна. Энэхүү түүхэн үйл явц нь дэлхийн олон оронд болж байгаа социалист ба ардчилсан соёлын зүйл бүрийн хэлбэрээр илрэн гарч байна.

Империализм ба социалист хувьсгалын эрин үед нийгмийн амьдралын бүх хэлбэр «үндсээрээ эвдрэх» тухай Лениний урьдчилсан дүгнэлт нь амьдралаар бүрэн нотлогдож байна. Ажилчин анги, хөдөлмөрчин олны хувьсгалт ухамсар хэлбэрэлтгүй дээшилж, империализмын дарлалаас чөлөөлөгдсөн ард түмэн, юуны өмнө социалист орнуудын ард түмний оюун санааны бүхий л амьдрал ба сэтгэхүй үндсээрээ өөрчлөгдөж байна.

Нийгмийн соёл болон оюун санааны амьдралд хувьсгалт эргэлт гарахын өмнө заавал нийгмийн хувьсгал болдог зүй тогтолтойг бодит социализмын хөгжлийн туршлага харуулж байна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн оюун санааны өөрчлөлт нь нийгэм улс төрийн байгуулах үндсээрээ хувьсан өөрчлөгдөхөөс бүрэн шалтгаалдаг болно. Нийгмийн оюун санааны

\* МАХН-ын Төв Хороо, «Энх тайван, социализмын асуудал» сэтгүүлийн газраас эрхлэн 1978 оны 6-р сарын 14--16-нд Улаанбаатарт «Аграр асуудал ба орчин үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалд тариачдын роль сэдвээр зохион явуулсан олон улсын онолын бага хурал дээр тавьсан илтгэл.

амьдрал нь гагцхүү нийгмийн хувьсгал гарсны дүнд буюу тухайн нийгэм, нэг нийгэм-эдийн засгийн хэвшлээс нөгөөд шилжин орсны дүнд л үндсээрээ эрс өөрчлөгддөг ажээ. Харин социалист соёлын хувьсгал бол нийгмийн оюун санааны амьдралыг үндсээр нь өөрчлөх бүхий л чухал нөхцөл бололцоог нь хангадаг болно. Соёлын хувьсгалын үйл явцад нийгмийн бүх давхарга, түүний дотор тариачдын оюун санаанд ч гүнзгий өөрчлөлт гардаг байна. Шинэ амьдралыг бүтээн байгуулах нийтлэг зүй тогтлын нэг болох соёлын хувьсгалын тухай Лениний сургаал одоогийн нөхцөлд улам бүр олон улсын чухал ач холбогдолтой болж байгааг онцлон тэмдэглэвэл зохино. Лениний энэхүү сургаалыг социалист орнуудад хэрэгжүүлсэн түүхэн туршлага бол нийгмийн дэвшлийн төлөө тэмцэж байгаа бүх ард түмэнд амин чухал ач холбогдолтой болж байна.

Монгол орон саяхан болтол Азийн ихэд хоцрогдсон орнуудын нэг байсныг хэн бүхэн сайн мэдэх билээ. Ийм орны нөхцөлд соёлын хувьсгалыг амжилттай явуулсан нь социализмд шилжих тодорхой хэлбэр болон тухайн хөгжлийн түвшнээс үл шалтгаалан социализмын замд орсон бүх оронд нийгмийн соёлын амьдралыг хувьсгалт ёсоор өөрчлөх тухай В. И. Лениний сургаал түгээмэл ач холбогдолтой болохыг хөдлөшгүй нотолж байна. Нөхөр Ю. Цэдэнбал соёлын хувьсгал бол урьд өмнө хоцрогдмол байсан орнуудын «капиталист биш хөгжлийн зүй тогтол»<sup>1</sup> мөн гэж тодорхойлсон билээ.

Социализмын үеийн соёлын хөгжлийн нийтлэг зүй тогтол болох соёлын хувьсгалын тухай ярихдаа бид, хөгжлийн социалист замыг сонгон авсан орон тус бүрийн өвөрмөц нөхцөлд энэ зүй тогтлын илрэн гарах тодорхой хэлбэрийн тухай асуудлыг мартаж болохгүй. Хөгжлийн капиталист шатыг алгасч социализмд шилжин орж байгаа орнуудад энэ зүй тогтлын илрэх хэлбэр капиталист харилцаанаас социализмд шууд орсон орнуудад мөнхүү зүй тогтол илэрч буй хэлбэрээс ялгаатай байна. Үүнийг БНМАУ-ын жишээнээс тодорхой үзэж болно.

1950-иад оны үесээр бид Монгол орон дахь соёлын хувьсгалын ардчилсан шатны тухай саналыг дэвшүүлсэн билээ. Энэ шат бол 1921—1940 оныг хүртэл үргэлжилсэн Монгол ардын хувьсгалын ардчилсан шаттай үндсэндээ тохирч байгаа бөгөөд БНМАУ-д социалист соёлын хувьсгалыг өрнүүлэн явуулахад нэгэн ёсны бэлтгэл үе байсан билээ. Манай орон дахь соёлын хувьсгалын энэ шатны үндсэн зорилт нь ард түмний ухамсрыг буддийн шашны харгис нөлөөнөөс ангижруулах, тэр үед тус улсын залуучуудын ихэнхийг хамарч байсан шашны олон сургуулийн оронд ардын боловсролын системийн үндсийг тавих, хүн амын бичиг үсэг нийтээр үл мэдэх явдалтай тэмцэх, шинэ хувьсгалт утга зохиол, урлагийг бий болгох, мөн түүнчлэн хөдөлмөрчин олон түмнийг оюун санааны хувьд чөлөөлөх талаар анхны хувьсгалт арга хэмжээнүүд авч явуулахад оршиж байлаа. Ийнхүү Монгол дахь соёлын хувьсгал хөгжлийнхөө анхны шатанд хувьсгалт ардчилсан шинжийг агуулж байсан бөгөөд ардын хувьсгалын ардчилсан шатны ерөнхий зорилтыг шийдвэрлэхэд чиглэгдэж байжээ. Чухам үүнд БНМАУ дахь соёлын хувьсгалын нэг чухал онцлог тал оршино.

Ардын хувьсгалын ардчилсан шатанд гарсан соёлын өөрчлөлт хэдийгээр шууд социалист шинжийг агуулж байгаагүй боловч, тэдгээр өөрчлөлт нь империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгалын ерөнхий зорилттой нягт холбоотой байсан учир хувьсгал улам бүр гүнзгийрэхийн хирээр социалист соёлын өөрчлөлтөнд хувиран орсон билээ.

1 Ю.Цэдэнбал. Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг, 5-р боть, 124-р тал

Энэхүү үйл явц нь улс төр, эдийн засаг зэрэг нийгмийн амьдралын бүх салбарт хувьсгалт ардчилсан өөрчлөлт социалист өөрчлөлт болон хувирсан явдалтай салшгүй холбоотой байжээ.

Ийнхүү хувьсгалын өмнөх Монгол мэтийн ихэд хоцрогдсон оронд жинхэнэ социалист соёлыг буй болгох зорилт бол бүх нийтийн оюун санааны амьдралын хүрээнд гүн гүнзгий ардчилсан өөрчлөлтийг туйлд нь хүртэл явуулж чадах эсэхээс шууд шалтгаалах ажээ.

Үүнтэй холбогдуулан дэлхийн анхны социалист орон ЗХУ болон ах дүү бусад орнуудын сэтгэл харамгүй тусламж манай орны соёлын хувьсгалыг амжилттай явуулахад шийдвэрлэх ач холбогдол бүхий гадаад хүчин зүйл болж байсныг онцлон тэмдэглэвээс зохино. Соёлын хувьсгал нь хаана ч боллоо гэсэн пролетарийн интернационализмын тугийн дор явагдах ёстой бөгөөд энэхүү хувьсгалд үндсэрхэх явцуу үзэл, жижиг хөрөнгөтний аливаа үзэл шууд харш юм.

Социалист орнуудын соёлын бүтээн байгуулалтын практик туршлагаас үзвээс тэдгээр оронд болсон нэгэн үндсэн утга агуулга бүхий социалист соёлын хувьсгал нь Мао Цзэ-дүн болон түүний хамсаатнуудын явууллагаар Хятадад бужигнан үймсэн эмгэнэлт үйл явдалтай өчүүхэн ч төсөөгүй, огт өөр зүйл мөн болох нь илэрхий байгаа юм. Хятадад болсон тэрхүү гунигт явдал бол соёлын хувьсгалын тухай Лениний агуу их сургаалыг хамгийн бүдүүлгээр доромжлон зөрчсөн хэрэг юм.

Монголын соёлын хувьсгалын анхны шатанд үзэгдсэн нилээдгүй адил төсөөтэй үйл явдал, БНМАУ-ын нэгэн адил хөгжлийн капиталист биш зам буюу социалист чиг баримжааг сонгон авсан хөгжиж байгаа хэсэг орны соёлын байгуулалтанд мөн нэгэн адил ажиглагдаж байна. Хөгжиж байгаа орнуудын соёлын бүтээн байгуулалтанд болж буй ардчилсан эрс шийдвэртэй өөрчлөлтүүдийг Зөвлөлтийн судлагч А. И. Арнольдов үндэсний ардчилсан хувьсгалын маяг<sup>2</sup>-т хамруулан тодорхойлжээ. А. И. Арнольдовын ном 1962 онд хэвлэгдсэн учир зохиогч нь социалист чиг баримжаагаар хөгжиж байгаа орнуудад явагдаж байгаа соёлын өөрчлөлтийн тухай урьдчилан бичих аргагүй байсан нь мэдээж хэрэг. Ийм учраас Зөвлөлтийн судлагчийн баримтлалыг цаашид тэмдэглэхэд, чухамхүү социалист чиг баримжаагаар хөгжиж буй орнуудад одоо үед авч явуулж байгаа соёлын арга хэмжээнүүд үнэхээр үндэсний ардчилсан соёлын хувьсгалын илэрхий шинж чанартай болох нь тодорхой байна.

Энэхүү соёлын хувьсгал, БНМАУ-ын соёлын хувьсгалын хувьсгалт ардчилсан шатанд шийдвэрлэсэн зорилтуудтай тун адил төсөөтэй асуудлыг шийдвэрлэж байна.

Үндэсний ардчилсан соёлын хувьсгал социалист маягт хувиран шилжих нь хөгжиж байгаа орнуудад капиталист биш хөгжил цаашид хэрхэн гүнзгийрэн явагдах ололт амжилтаас шууд шалтгаалах болно гэдгийг БНМАУ-ын соёлын хувьсгалын туршлагад тулгуурлан хэлж болно.

Харин дээрх орнуудын хүн амын нийгмийн бүх давхарга, түүний дотор тариачдын оюун санааны амжилтын өөрчлөлт нь эцсийн бүлэгт соёлын хувьсгалын үндсэн зорилтыг хэрхэн шийдвэрлэснээс бүрэн шалтгаалах ажээ.

Ардын засгийн жилүүдэд монголын нийгмийн оюун санааны амьдралд гарсан бүх өөрчлөлт нь БНМАУ-д жинхэнэ соёлын хувьсгалыг амжилттай явуулж чадсаны зүй ёсны үр дүн мөн. Ардын хувьсгалын өмнө монголын малчин ард ямаршүү их харанхуй бүдүүлэг хүнд нөхцөлд оршиж байсан нь бүхнээ илэрхий билээ. Ардууд феодалын дааж давшгүй

алба гувчуурт дарагдаж, хятадын мөнгө хүүлэгчдийн өрөнд баригдан туйлын ядуу зүдүү, эрх мэдэлгүй, бүдүүлэг байсан билээ. Энэ байдлын тухай Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Д. Нацагдорж 1930 онд «Хуучин хүү» өгүүллэгдээ уран яруу өгүүлсэн нь: «...хэлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.

Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном гэж буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж, хууль ёс гэж худал үнэн ярихыг сонссоор, өдөр сарыг улируулна.

Тэртээ уулыг өнгөрвөл айлгүй гэж бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч дэлхийн боловсролоос гээгдэнэ.

Гагцхүү өглөө бурханд залбирч, үдэш тэнгэрт мөргөсөөр, нэг нас барна

..Өтгөс хуучид энэ хоёрын үгнээс бус үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй гэж санаж хөмөрсөн тогооны доторхитой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ.

Юутай гомдолтой зэрлэг амьдрал, юутай хайрлалтай залуу нас, юунд шинэ ертөнцийг үзэхийг үл хүснэ».<sup>3</sup>

Тийм байдлыг гагцхүү Монгол ардын хувьсгалын ялалт эцэс болгож, ард түмний оюун санаа бүхий л талаар сэргэн мандахын өргөн бололцоог нээсэн билээ.

БНМАУ-д хөдөө аж ахуйг социалист ёсоор хоршооллосон нь хөдөлмөрчин ардын амьдралын бүх салбарт гүн гүнзгий өөрчлөлт гарахын эх булаг болсон юм. Хүн хүнээ дарлан мөлжихийн нийгмийн үндэс үүрд устаж, жижиг хувийн өмчтөний ангийн оронд социализмын замаар аж төрж буй хоршооллосон малчин ардын буюу огт шинэ анги бүрэлдэн тогтлоо.

Малчин ардын дунд ядуу, дунд, чинээлэг гэгдэх давхарга устав. Малчин ардын материаллаг соёлын хэмжээ, түүний өмч хөрөнгийн байдлаар буюу баялгаар хэмжигдэх бус, харин тэрхүү малчны амьдарч буй хөдөө аж ахуйн нэгдлийн нийгмийн үйлдвэрлэлийн түвшин, нэгдлийн гишүүн тэр хүн нийгмийн хөдөлмөрт хэрхэн оролцож байгаа хэмжээгээр нэгэнт тодорхойлогдох болжээ. Товчоор хэлбээс, материаллаг болон соёлын баялгийг бүтээх ба хувиарлахад жирийн нэг ард хэн боловч тэгш эрхтэй оролцох бололцоо нөхцөлтэй болжээ. Нүүдэл суудлын амьдралын хоцрогдсон хэлбэр маяг арилж, хөдөлмөрчин ард олны соёл ахуйн нөхцөл улам бүр сайжирсаар байна. Хөдөө нутагт суурьших үйл явц аажмаар явагдаж байна. Хөдөөгийн барилга байгууламжийг хөгжүүлэх, тухайлбал өвөлжөө, бууц, бригадын төвийг тохижуулах, өргөн айлсалтын хөдөлгөөнийг өрнүүлэх явдал малчдын соёл ахуйн нөхцлийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм. Хөдөө аж ахуйн нэгдэл бүр сургууль, хүн эмнэлгийн салбар, мал эмнэлгийн хэсэг, клуб, нүүдлийн кино, цахилгаан станц, радио цэг, халуун ус, зочид буудал, хүүхдийн цэцэрлэг зэрэг соёл ахуйн газруудтай болжээ. Монголын малчдын уламжлалт сууц гэр ч хүртэл багагүй өөр болжээ. Гадаадын жуулчин-судлагчид хир тоосондоо дарагдсан авдар сав бүхий, утаа тортог болсон гэрийн тухай нүүдлийн амьдралын нэгэн этгээд сонин зүйл гэж саяхан болтол гайхан бичиж байсан билээ. Гэтэл одоо гэрийн гадаад дотоод байдал төрх баялаг чинээлэг, цэвэр тохилог болж дотор нь орчин цагийн гэр ахуйн хогшил хэрэглэл ердийн үзэгдэл болжээ. Хөдөөд бичиг үсэг үл мэдэх явдал арилж, хүн бүр

3 Д. Нацагдорж. Зохиолууд, УБ, УХХЭХ, 1961, 208—209-р тал.

нийтээрээ анхан шатны боловсролтой болсон ба бүх нийтийг 8 жилийн боловсролтой болгох зорилт амжилттай хэрэгжиж байна. Одоо хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн төвийн 94% нь дунд сургуультай болжээ. Насанд хүрсэн хүмүүсийг ихэвчлэн оройн сургууль, дугуйлангаар сурган, ерөнхий боловсролыг нь дээшлүүлж байна.

Одоо манай оронд социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх үйл явц хүн амын бүх давхарга, түүний дотор хөдөөгийн хөдөлмөрчдийг бүрэн хамран явагдаж байна. Үүнтэй уялдуулан одоогийн монголын малчин ард социалист аж төрөх ёсны гол шалгуур болох хөдөлмөрт хэрхэн хандаж байгаа асуудлыг авч үзье. Социализмын нөхцөлд «нийгмийн тусын төлөө хувийн эрх ашгийг үл хайхран хөдөлмөрлөх явдал» хүн бүрийн төрөлхийн хэрэгцээ шаардлага болдог байна.

В. И. Лениний зааснаар социализмын мөн чанар бол «...албадлагын хөдөлмөрийг өөртөө хөдөлмөрлөх хөдөлмөрөөр, нийт улсын (зохио хэм жээгээр интернационализм ба дэлхий дахины) аврага хэмжээгээр төлөвлөгөөтэй зохион байгуулсан хөдөлмөрөөр халж байгаа энэ их өөрчлөлт»<sup>4</sup> явагдахад оршино.

Ийнхүү социализмын үед хөдөлмөр дарлал мөлжлөгийн зэвсэг байхаа больж, нийгмийн материаллаг болон оюуны баялгийг өсгөн нэмэгдүүлэх гол эх үүсвэр, шинэ хүний өв тэгш хөгжлийг хангах үндэс болжээ.

Одоо үед Монголд хөдөлмөрчин олон түмнээс хөдөлмөрт хандах явдал олон үзүүлэлтээр илэрч байна. Үүнд: Жишээ нь, нийгмийн өмнө хүлээсэн өөрийн үүрэг даалгаврыг ухамсартай биелүүлэх, хөдөлмөрийн сахилга батыг нарийн чанд сахих ба ажлын цагийг бүрэн ашиглах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ерөнхий боловсролын болон шинжлэх ухаан техникийн мэдлэг мэргэшлийн төвшингөө дээшлүүлэхийг сонирхох социалист уралдаан болон социалист хөдөлмөрийн төлөө хөдөлгөөнд нийтээрээ өргөн оролцох зэргээр илэрч байна.

Монголд социализмын үеийн шинэ хүн төрөн бойжсон явдал бол нийгмийн оюун санааны ертөнц үндсээрээ өөрчлөгдсөний нэг чухал үр дагавар даруй мөн. Хөдөө аж ахуйн тэргүүний сайчуулын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, зөвхөн сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн хэдэн мянган хүн засгийн дээд шагналаар шагнагдаж, 60 гаруй хүн хөдөлмөрийн баатрын хүндэт цолыг хүртжээ. Мөн шинэ хүний оюун санааны төрх байдлыг хөдөө аж ахуйн хөдөлмөрчдийн өөрсдийн нь хэлсэн үгнээс харж болно.

Төв аймгийн Бүрэн дэлгэрэх нэгдлийн алдарт хоньчин нөхөр Т. Ширчингийн хэлсэн нь: «Малчин бидний үндсэн зорилт бол социалист өмч, нийгмийн баялгийг нэмэгдүүлэн, арвижуулж, хайр гамтай ашиглах явдал мөн. Учир нь социалист өмч нийгмийн баялаг хичнээн арвин байвал хүн бүхэн сайн сайхан амьдарч, нийгэм маань хөгжин бэхжих нь мэдээж билээ. ...Хөдөлмөр бол хүнд, аз жаргал, баяр баясгалан, сайн сайхан бүхнийг авчирдаг болохоор малчид бид хөдөлмөрийн үр шимийг дүүрэн ойлгож, тэр чанараараа хөдөлмөрийг хүндэтгэн нэр төр, алдар гавьяаны хэрэг болгон үздэг боллоо.

...Жирийн нэг хоньчин би бусад хөдөлмөрчдийн хамт төрөлх эх орондоо социализм байгуулах хувь ноогдсондоо баярлан бахархаж явдаг юм»<sup>5</sup>

Орчин үеийн монголын шинэ хүнийг Д. Нацагдоржийн «Хуучин хүү» тэй харьцуулбал ардын засгийн жилүүдэд монголын малчин ардын сэтгэхүй, оюун санааны төрх байдал хичнээн их өөрчлөгдсөнийг төсөөлөн ойлгоход төдий л хэцүү бус байна. Энэ жишээ бол гагцхүү социализм л

4 В. И. Ленин. Зохиолууд. 25-р боть, 41-р тал

5 БНМАУ-ын Хөдөө аж ахуйн нэгдлийн холбооны 4-р их хурал. 1973 оны зургадугаар сарын 11-13. Дэлгэрэнгүй тайлан. УБ, 1975. 59-р тал.

хүний амьдралын нийгмийн нөхцлийг төдийгүй мөн хүний өөрийнх нь төрөлхийн мөн чанарыг үндсээр нь өөрчилж чаддагийн наад захын тодорхой нэг жишээ мөн.

Колоничлолын ноёрхлын үед Ази, Африкийн олон орон орчин үеийн хөгжлийн төвшингөөс хэт их хоцрогдсоны үнэнхүү шалтгааныг нуун далдалахыг оролдохдоо хөрөнгөтний үзэл сурталчид «бүрэн хөгжсөн» ба «бүрэн бус хөгжсөн» арьстны тухай, шинжлэх ухааны эсрэг онолыг санаанаасаа зохиож, «бүрэн бус хөгжсөн» арьстны тоонд хар, шар арьстныг оруулдаг билээ. Тэдний хоцрогдлын учир шалтгааныг биологийн болон төрөлхийн оюун билгийн ялгаанаас болдог гэж номлож байна. Янз бүрийн анги, ард түмний төлөөлөгчдийн ёс суртахууны болон бие бялдрын хөгжлийн төвшний ялгаатай байгаагийн үнэнхүү шалтгааныг чухамхүү марксизм-ленинизм нээж олсон гавьяатай болно. Энэхүү сургаал ёсоор уг шалтгаан нь хүмүүсийн оюун санааны болон биологийн чанарын онцлогт биш, харин улс түмний нийгмийн байгуулалтын шинж чанарт оршино. Марксизм-ленинзмийн энэхүү дүгнэлт байгалийн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтоор давхар нотлогдож байгаа юм.

Москва хотноо 1964 оны 8-р сард ЮНЕСКО-гийн санаачлагаар арьстны тухай биологийн асуудлаар болсон олон улсын Симпозиумаас батлан гаргасан тунхаглалд, дэлхийн ард түмэн одоо соёл иргэншлийн аливаа төвшинд хүрэх биологийн адил тэгш боломжтой бөгөөд «янз бүрийн ард түмний ололт амжилтын ялгааг гагцхүү түүх соёлын асуудлаар тайлбарлах ёстой»<sup>6</sup> гэж заажээ. Мөнхүү тунхаглалд цааш нь тэмдэглэсэнчилэн «Соёлын ололтонд хүрэх удамшлын боломж болон оюун ухааны ердийн хөгжлийн авьяас чадвар, мөн түүнчлэн бие бялдрын шинж тэмдгийг хувьд «дээд» ба «доод»<sup>7</sup> арьстны тухай онолыг цагаатган зөвтгөж болохгүй.

Шинжлэх ухааны дээрх бүх дүгнэлтийн үнэн болохыг орчин цагийн дэлхий ертөнцийн хөгжлийн бүх явц хөдлөшгүй нотолж байна.

**Ш. Бира**

## НАУЧНЫЙ СОЦИАЛИЗМ И ПРЕОБРАЗОВАНИЕ ДУХОВНОГО МИРА КРЕСТЬЯНСТВА

### Резюме

Вопрос о духовной жизни общества, в частности, о духовной жизни крестьянства-подавляющего большинства населения бывших колониальных и зависимых стран, является одной из острейших и актуальных проблем социального развития в современную эпоху.

В настоящее время в мире происходит двуединый процесс: с одной стороны сближение и интернационализация духовной жизни народов в социалистических странах, а с другой-возрождение национальной культуры и усиление национального самосознания бывших колониальных и зависимых народов Азии, Африки и Латинской Америки. Этот исторический

6 «Курьер ЮНЕСКО», Апрель 1965, стр. 11.

7 «Курьер ЮНЕСКО» Апрель 1965, стр. 11

процесс проявляется в разнообразных формах развития социалистической и демократической культуры в разных странах мира.

Необходимо особо подчеркнуть тот факт, что ленинское учение о культурной революции как одна из общих закономерностей строительства новой жизни приобретает в нынешних условиях все более и более международное значение. А исторический опыт претворения в жизнь этого ленинского учения в социалистических странах имеет жизненно важное значение для всех народов, борющихся за социальный прогресс.

Успешное проведение культурной революции в условиях Монголии, которая, как известно, являлась в недавнем прошлом одной из наиболее отсталых стран в Азии, наглядно подтверждает универсальное значение ленинского учения о революционной перестройке культурной жизни общества для стран, вставших на путь социализма, независимо от уровня их развития и форм перехода к социализму. Товарищ Ю. Цеденбал назвал культурную революцию «закономерностью некапиталистического развития» отсталых в прошлом стран.

Практика и опыт культурного строительства в социалистических странах яснее всего показывают, что единая по своему основному содержанию социалистическая культурная революция, которая имела место в этих странах, ничего общего не имеет с теми трагическими событиями, которые разыгрались в Китае под указкой Мао Цзэ-дуна и его единомышленников, и которые были не чем иным, как грубейшим поруганием великого ленинского учения о культурной революции.

Весьма аналогичные с революционно-демократическим этапом культурной революции в Монголии явления в настоящее время мы наблюдаем в области культурного строительства в ряде развивающихся стран, избравших социалистическую ориентацию.

На опыте культурной революции Монголии можно заключить, что перерастание национально-демократической культурной революции в высший, социалистический тип культурной революции зависит от успехов дальнейшего углубления некапиталистического развития развивающихся стран. А успехи в духовных преобразованиях всех социальных слоев населения, в том числе и крестьянства. В этих странах в свою очередь не посредственно зависят от решения коренных задач культурной революции. В этой связи автор подчеркивает особую роль, которую играет кооперирование сельского хозяйства на социалистических началах. Приводятся наглядные примеры из жизни современного кооперированного монгольского аратства.

В заключение автор подвергает критике антинаучную теорию буржуазных идеологов о «полноценных» и «неполноценных» расах, согласно которой корни социального и духовного отставания отдельных народов следует искать в различии природных, биологических и духовных дарований людей, относящихся к различным расам. Заслуга марксизма-ленинизма заключается, в частности, в том, что именно это учение открыло подлинные причины разного уровня нравственного и физического развития представителей разных классов и народов. Согласно марксизму-ленинизму, эти причины коренятся в характере социальной организации жизни народов, а не в особенностях биологических и духовных качеств людей. Этот вывод марксизма-ленинизма подтверждается всем ходом развития современного мира.